



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/458

Мөрөн сум

Барилга, байгууламжийн ажил хүлээж
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд баригдсан Сум дундын ойн ангийн байрны барилгын ажлыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Л.Бямбасүрэн

(Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

Б.Аюуш

(Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн Ашиглалтын албаны дарга)

Э.Сумъяасүрэн

(“Хөвсгөл барилга захилагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ газрын хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

А.Ганхуяг

(“Гранд лайн проект” ХХК-ийн инженер)

Гүйцэтгэл байгууллагын төлөөлөл:

Ж.Төмөрбат

(“Хигүүр ой” ХХК-ийн Захирагч)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

А.Батмөнх

(Цагаан-Үүр сумын Засаг дарга)

6711011788

М.Март

(Нарс, Шинэсэн төгөл Сум дундын ойн
ангийн дарга)

Комиссын нарийн бичгийн дарга:
Д.Нямбат

(Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)


2. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР